



ТӨВ АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ 2022 ОНЫ 12 САРД
БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАНИЛЦУУЛГА


2023.01.05

Зуунмод сум


**НЭГ. ДУУДЛАГА МЭДЭЭЛЭЛ, ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН
ШИНЖТЭЙ ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН ШИЙДВЭРЛЭЛТ**

Тус Цагдаагийн газарт 2022 оны 12 дугаар сард нийт 3846 дуудлага мэдээлэл хүлээн авсныг урьд оны мөн үетэй харьцуулахад 26 дуудлага мэдээллээр буюу 0,6 хувиар **буурсан** байна. /Урьд онд 3872/

Дуудлага мэдээллийг төрлөөр нь харуулбал:



Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 4481 гомдол мэдээлэл хүлээн авсан, өмнөх үлдэгдэл гомдол 38, нийт 4519 гомдол мэдээлэл шалгаснаас хуулийн хугацаанд 4022 буюу 98,3 хувийг шийдвэрлэсэн байна. /Үлдэгдэл 76/
Бүртгэгдсэн гомдол, мэдээллийг өнгөөр нь авч үзвэл:



Үүнээс гэмт хэргийн шинжтэй 1750 гомдол хүлээн авснаас 1696 буюу 96,9 хувийг шийдвэрлэж, 54 гомдлын үлдэгдэлтэй байна. Шийдвэрлэсэн байдлыг авч үзвэл:


- Хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 485 буюу 28,5 хувь
- Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан 1192 буюу 70,2 хувь
- Харьяаллын дагуу шилжүүлсэн-19

Гэмт хэргийн шинжтэй нийт шийдвэрлэсэн 1696 гомдол мэдээллийн 1232 буюу 72,6 хувийг 5 хоногт, 453 буюу 26,7 хувийг 6-19 хоногт шийдвэрлэсэн байна. 20 ба түүнээс дээш хоногоор шийдвэрлэсэн гомдол мэдээлэл 11 байна.

ХОЁР. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ТҮҮНИЙ ХӨДӨЛГӨӨН

2022 оны 12 сард 754 **гэмт хэрэг** бүртгэгдсэн нь 143 хэргээр буюу 23,4 хувиар **өссөн**, / Урьд онд 611/, хэрэг бүртгэлтийн 663 хэрэг бүртгэгдсэний 426 хэргийг илрүүлж, илрүүлэлт 64,3 хувьтай, өмнөх оны мөн үетэй харьцуулахад **илрүүлэлт 4,7 хувиар өссөн** байна. /өмнөх онд 59,5%/.


Сумдад бүртгэгдсэн хэрэг:



Бүртгэгдсэн гэмт хэргийг урьд оны мөн үетэй харьцуулахад:

- Зуунмод сум 56 нэгжээр
- Батсүмбэр сум 16 нэгжээр
- Заамар сум 10 нэгжээр
- Лүн сум 11 нэгжээр
- Сэргэлэн 19 нэгжээр тус тус өссөн байна.

Бүртгэгдсэн хэрэг /өнгөөр/:



Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг хэрэг 281 бүртгэгдсэн нь 25 хэргээр буюу 9,7 хувь, хүнийг алах хэрэг 13 бүртгэгдсэн нь 8 хэргээр буюу 1,6 дахин их


хувь, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын гэмт хэрэг 18 бүртгэгдсэн нь 3 хэргээр буюу 20 хувь, хулгайлах гэмт хэрэг 138 бүртгэгдсэн нь 42 хэргээр буюу 44,7 хувь, мал хулгайлах 61 бүртгэгдсэн нь 22 хэргээр буюу 56,4 хувь, хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 84 бүртгэгдсэн нь 34 хэрэг буюу 68 хувиар тус тус өссөн байна.

Нийт гэмт хэрэгт эзлэх хувиар авч үзвэл: Өмчлөх эрхийн эсрэг 296 бүртгэгдсэн нь 39,2 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 84 бүртгэгдсэн нь 11,1 хувийг, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг хэрэг 281 бүртгэгдсэн нь 37,2 хувийг тус тус эзэлж байна.

Хэргийн гаралт, илрүүлэлт:

Д/д	Үзүүлэлт	2021 он	2022 он	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг	611	754	143	23,4%+
2	Хэрэг бүртгэлтийн хэрэг	383	663	280	73,1%+
3	Үүнээс: Илэрсэн хэрэг	228	426	198	86,8%+
4	Илрүүлэлтийн хувь	59,5%	64,3%	4,7%+	

Гэмт хэргийн илрүүлэлт төвийн бүсийн аймгуудтай харьцуулахад



Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал:

Үзүүлэлт	2021 он	2022 он	Өсөлт бууралт /%-р/
Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг	54	53	-1 нэгжээр буюу 1,8%-

Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг	154	212	58 нэгжээр буюу 37,6%+
Хүүхэд оролцсон гэмт хэрэг	9	10	1 нэгжээр буюу 11,1%+
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэг	61	54	-7 нэгжээр буюу 11,4%-
Бүлгээр үйлдэгдсэн хэрэг	25	30	5 нэгжээр буюу 20%+

Гэмт хэргийн улмаас хохирсон хүний тоо 767 байгаагаас эмэгтэй хүн 284, хүүхэд 35 байна.

2022 оны 12 сард иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад 6 тэрбум 691 сая төгрөгийн хохирол учирч үүнээс 3 тэрбум 521 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлт **49,2** хувьтай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад **-28,7** хувиар **буурсан** байна. /Урьд онд 77,9%/

Гэмт хэрэг үйлдэгдсэн гараг, цаг хугацаагаар нь авч үзвэл:

Огноо	Нийт хэрэг	Гэмт хэрэг үйлдэгдсэн гараг							Хэрэг үйлдэгдсэн цаг			
		даваа	мягмар	лхагва	пүрэв	баасан	бямба	ням	06-14	14-19	19-22	22-06
2022 оны 12 сар	754	112	113	118	80	119	112	100	149	215	152	238

2022 оны 12 дугаар сард Мягмар, Лхагва, Баасан, гаригт хамгийн их буюу 350 гэмт хэрэг нийт гэмт хэргийн 46,4 хувь нь бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг үйлдэгдсэн газраар нь харьцуулан авч үзвэл:




Бүртгэгдсэн гэмт хэргээс гэр орон сууцанд 208 буюу 27,5 хувийг, гудамж талбайд 53 буюу 7 хувийг, олон нийтийн газар 25 буюу 3,3 хувийг, аж ахуй нэгж 25 буюу 3,3 хувийг, бусад газар 371 буюу 49,2 хувийг, авто замд 67 буюу 8,8 хувь нь тус тус үйлдэгдсэн байна.

ГУРАВ: ЗӨРЧЛИЙН ШИНЖТЭЙ ДУУДЛАГА МЭДЭЭЛЭЛ, ЗӨРЧЛИЙН ШИНЖТЭЙ ГОМДОЛ МЭДЭЭЛЭЛ, ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ


Тус Цагдаагийн газарт 2022 оны 12 сард өссөн дүнгээр 3845 дуудлага мэдээлэл хүлээн авсныг урьд оны мөн үетэй харьцуулахад -27 дуудлага мэдээллээр буюу -0,6 хувиар **буурсан** байна. /Урьд онд 3872/

Дуудлага мэдээллийг төрлөөр нь харуулбал:




Зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлт:

Зөрчлийн шинжтэй нийт 2769 гомдлыг хүлээн авч 2747 буюу 99,2 хувийг нь шийдвэрлэж 22 гомдлын үлдэгдэлтэй байна. Шийдвэрлэлтийн байдлыг авч үзвэл:




Хүлээн авсан захиргааны зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийг хугацаагаар нь харуулбал;



Тус Цагдаагийн газарт нийт 57821 **зөрчил** хүлээн авснаас 57812 буюу 99,9 хувийг шийдвэрлэсэн ба урьд оны мөн үетэй харьцуулахад хүлээн авсан зөрчил 21664 буюу 59,9 хувиар **өссөн** үзүүлэлттэй байна. /Урьд онд 36157/

Зөрчлийг төвийн бүсийн аймгуудын цагдаагийн газар хэлтсүүдтэй




харьцуулбал:

Нийт шалгасан зөрчлөөрөө **1 дүгээр байрт** орсон байна.

2022 оны 12 сард ердийн журмаар шийдвэрлэсэн нийт 55070 зөрчил бүртгэгдсэн нь нийт шийдвэрлэсэн зөрчлийн 95,2 хувийг эзэлж байна.

Зөрчлийн хэрэг нээсэн болон хялбаршуулсан зөрчил




Зөрчлийн шийдвэрлэлт:




- 567 иргэнийг баривчилж,
- 1190 иргэнийг торгож, эрх хасах шийтгэл ногдуулсан.

Төв аймгийн хэмжээнд баривчлагдсан хүн 19,3 хувиар, торгож, эрх хассан хүн 8,8 хувиар өссөн байна.

Зөрчлийг хэрэг нээж, шүүхээр баривчлуулсан байдлыг бусад төвийн бүсийн Аймгуудын Цагдаагийн газар хэлтэстэй харьцуулахад:




Зөрчил үйлдэгдсэн газар, зөрчлийн тоо:



Нийт бүртгэгдсэн зөрчлийн гэр орон сууцанд 358 буюу 13 хувь, гудамж талбайд 346 буюу 12,5 хувь, зам дээр үйлдэгдсэн 1783 буюу 64,8 хувь тус тус үйлдэгдсэн байна.


Зөрчил үйлдэгдсэн газраар нь харьцуулан үзэхэд зам, гэр орон сууцанд, гудамж талбайд хамгийн ихээр үйлдэгдсэн байна.

Зөрчлийн үйлдэгдсэн гараг нь:




Бүртгэгдсэн нийт зөрчлийн 8101 буюу 14 хувь нь даваа гаригт, 8347 буюу 14,4 хувь нь мягмар гаригт, 9021 буюу 15,6 хувь лхагва гаригт, 8748 буюу 15,1 хувь нь пүрэв гаригт, 8370 буюу 14,4 хувь нь баасан гаригт, 7674 буюу 13,2 хувь нь бямба гаригт, 7560 буюу 13 хувь нь ням гаригт тус бүр үйлдэгдсэн байна.

Зөрчил үйлдэгдсэн цаг хугацаа нь:



Бүртгэгдсэн нийт 57821 захиргааны зөрчлийн үйлдэгдсэн цаг: 06-12 цагт 11938 буюу 20,6 хувь, 13-18 цагт 28834 буюу 49,8 хувь, 19-24 цагт 15578 буюу 26,9 хувь, 01-05 цагт 1471 буюу 2,5 хувь нь үйлдэгдсэн байна.

Зөрчил үйлдэгдсэн онцлог:



ДӨРӨВ: ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

Аймаг орон нутгаас тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах зорилгоор зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх “Архигүй жолоо-Аюулгүй-80”, “Хурд”, “Хяналт шалгалт”, “Гэрэлтүүлэг”, “Ачааны автомашины бүрэн бүтэн байдал”, “Согтуу” мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Алдуул мал”, “Туслах малчин”, “Наадам”, архидан согтуурах, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх чиглэлээр “Архи” “Хамтдаа сэргийлье”, “Архигүй үлгэрлэе”, “Сайн хөрш-2022”, “Хүчирхийлэл хүн бүрд хамаатай”, “Судалгаа”, “Судалгаа хяналт”, “Тоглоомын талбай”, “Орц” гэмт хэрэг, зөрчил үйлдээд оргон зайлсан этгээдүүдийг олж тогтоох зорилгоор “Оргодол”, “Зөрчил эрэн сурвалжит”, “Эрэн сурвалжлалт-2”, “Мэдээ мэдээлэл” цагдаагийн байгууллагын нэгдсэн сангийн бүртгэлтэй тулгалт хийх “Сангийн тулгалт-2022”, Зөрчил шалгаж байгаа алба хаагч нарын ажлын үзүүлэлтийг сайжруулах, “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль”-инд заасан эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулсан, албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийн биелэлтийг хангуулах “Торгууль-Биелэлт”, “Зөрчлийн хэргийн шийдвэрлэлт” зэрэг 24 арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулан ажилласан байна.

Архидан согтуурахтай тэмцэх, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, “Амос”, “Аз жаргалын хөг аялгуу”, “Эрчим клуб”, “Инээмсэглэж буй гэр бүл” төрийн бус байгууллагатай хамтран 5 удаа архины хамааралтай гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг 286 иргэд, олон нийтийн газар иргэдийн дунд архи, тамхины хор уршиг, түүнээс хэрхэн гарах талаарх соён гэгээрүүлэх сургалт, урлаг соёлын арга хэмжээг зохион байгуулан ажилласан. Аймгийн хэмжээнд мөрдөгдөж байгаа архи согтууруулах төрлийн худалдан борлуулдаг худалдаа, үйлчилгээний газруудын ажиллах цагийн хуваарь, хязгаарлалтын асуудлаар ажлын хэсгийн болон худалдаа үйлчилгээ эрхлэгч нартай-2, Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн эрхийг хангах чиглэлээр Зуунмод-13, хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс

урьдчилан сэргийлэх Баян, Баянчандмань сумын хамтарсан багийн гишүүд, Баянхангай суманд 7 сум, Дэлгархаан, Баянжаргалан, Баянцагаан, Алтанбулаг, Аргалант, Сүмбэр сумын 18 малчдын бүлгийн гишүүдтэй уулзалт, Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, төв телевизтэй хамтран “Шүгэл” нэршилтэй хэлэлцүүлэгийг зохион байгуулсан.

Төв аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Зуунмод сумын Засаг даргын тамгын газар, Дэлхийн зөн олон улсын байгууллагын төв орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр “ҮНЭ ЦЭНТЭЙ АМЬДРАЛ” төслийн хүрээнд Зуунмод сумын 6 багийн 60 иргэдийг 3 хуваан халдвар хамгааллын дэглэм сахиулан “Үнэ цэнтэй амьдрал”,

-Архуст, Баян, Баянчандмань, Баянцогт, Борнуур, Дэлгэрхаан, Баянхангай, Эрдэнэсант, Лүн, Цээл, Угтаал, Бүрэн, Баянцагаан, Лүн, Цээл, Баянжаргалан, Жаргалант, Баяндэлгэр, Эрдэнэ, Заамар, Зуунмод сумын 6 баг зэрэг 26 сумдад “Төлөөлөгчийн нэг өдөр”, “Малчдын зөвлөгөөн” өдөрлөгийн арга хэмжээг сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохицуулах зөвлөл, Засаг даргын тамгын газартай хамтран зохион байгуулсан.

- “Аажуу явбал аяндаа хүрнэ дээ” арга хэмжээний хүрээнд Улаанбаатар-Говь-Сүмбэр А0101, Улаанбаатар-Арвайхээр А0103, Улаанбаатар-Говьсүмбэр А0101, Улаанбаатар-Хэнтий А0501 чиглэлийн автозам дээр аймгийн Нэгдсэн эмнэлэг, Улаан загалмайн нийгэмлэгийн салбар, МИГ, Монгол даатгал, Өвөржанчивлан рашаан сувиллын ажилтан, алба хаагч нартай хамтран зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх 4 удаагийн “Өдөрлөг”-ийг зохион байгуулан жолоочид хүргэх зурвас, хөдөлгөөнд оролцож байхдаа хориглох зүйлүүд, нүд амраах дасгал ослын үед жолооч, зорчин явагч нар хохирогчид анхны тусламжийг хэрхэн үзүүлэх талаарх үзүүлэх дадлага сургалтыг алба хаагч нартаа хамтран үзүүллээ.

ТАВ: ДҮГНЭЛТ:

Гэмт хэргийн талаар: Тус цагдаагийн газарт 2022 оны 12 сард өссөн дүнгээр 754 гэмт хэрэг бүртгэгдэж хэргийн илрүүлэлт 64,3 хувьтай, улсын дундаж илрүүлэлт 54,2 хувь байгаа нь 10,1 хувиар их байна. Бүртгэгдсэн нийт гэмт хэргээс 620 буюу 82,2 хувийг хөнгөн, 134 буюу 17,7 хувийг хүнд гэмт хэрэг эзэлж, хөнгөн гэмт хэргийн илрүүлэлт 65,3 хувьтай, хүнд гэмт хэргийн илрүүлэлт 59,3 хувьтай байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэргийн илрүүлэлт 3,5 хувиар өссөн, хүнд гэмт хэргийн илрүүлэлт 10 хувиар өссөн эерэг үзүүлэлттэй байна.

Хохирол нөхөн төлүүлэлт 49,2 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад - **28,7 хувиар буурсан үзүүлэлттэй** байна.

Зарим төрлийн гэмт хэргийн өсөлт бууралтын талаар: Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг хэрэг 281 бүртгэгдсэн нь 25 хэргээр буюу 9,7 хувь, хүнийг алах хэрэг 13 бүртгэгдсэн нь 8 хэргээр буюу 1,6 дахин их хувь, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын гэмт хэрэг 18 бүртгэгдсэн нь 3 хэргээр буюу 20 хувь, хулгайлах гэмт хэрэг 138 бүртгэгдсэн нь 42 хэргээр буюу 44,7 хувь, мал хулгайлах 61 бүртгэгдсэн нь 22 хэргээр буюу 56,4 хувь, хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 84 бүртгэгдсэн нь 34 хэрэг буюу 68 хувиар тус тус өссөн.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг хэрэг 296 бүртгэгдсэнээс хэрэг бүртгэлтийн 293 үүнээс 134 хэргийг яллагдагчаар татан илрээгүй 45,7 хэрэг байна. Үүнээс хулгайлах гэмт хэрэг 138 бүртгэгдсэнээс 37 хэргийг яллагдагчаар татаж илрүүлэлт 26,8 хувьтай байна,

Залилан мэхлэх гэмт хэрэг 71 бүртгэгдэж 49 нэгжээр буюу 2,2 дахин их хувиар өссөн үүнээс цахим залилангийн гэмт хэрэг 99 хувийг эзэлж байгаад дүгнэлт хийн урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх,

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 33 бүртгэгдсэн нь -22 нэгжээр буюу -40 хувиар буурч хэргийн илрүүлэлт 44,8 хувьтай урьд оны мөн үеэс -29,7 хувиар **буурсан байдалд дүгнэлт хийх,**

Мал хулгайлах гэмт хэрэг 61 бүртгэгдсэнээс 50 хэргийг яллагдагчаар татаж хэргийн илрүүлэлт **82 хувьтай** хэргийн илрүүлэлт 5,7 хувиар өссөн **эерэг үзүүлэлттэй** байна.

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг зөрчлийн талаар: 2022 оны 12 сард өссөн дүнгээр хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 84 бүртгэгдсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад 34 буюу 68 хувиар өссөн байх ба уг гэмт хэргийн улмаас 28 хүн нас барж 65 хүн гэмтсэн байна.



Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих /14.7/ зөрчил тус аймгийн нутаг дэвсгэрт 12 сарын байдлаар өссөн дүнгээр 49838 зөрчил бүртгэгдсэн нь нийт бүртгэгдсэн зөрчил /57821/-ийн 80,2 хувийг эзэлж байна. Дээрх зөрчилд 49838 иргэнийг 1452470,0 төгрөгөөр торгож 1190 иргэний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг зөрчлийн тухай хуульд зааснаар хасаж, торгосон, 274 иргэнийг шүүхийн шийтгэврээр баривчлуулж шийдвэрлүүлсэн байна.

Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг зөрчлийн талаар: 2022 оны 12 сарын байдлаар гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 2 бүртгэгдсэн нь урд оны мөн үеэс -6 нэгжээр буюу -75 буурсан, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 54 бүртгэгдсэн нь -7 нэгжээр буюу -11,4 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчсөн 301 зөрчил хүлээн авч 258 иргэнийг шүүхийн шийтгэврээр баривчлуулж 17 хүнийг 2480,0 төгрөгөөр торгож шийдвэрлэсэн байна.

Зөрчлийн талаар: Аймгийн нутаг дэвсгэрт нийт 57821 зөрчил хүлээн авснаас 57812 буюу 99,9 хувийг шийдвэрлэсэн ба урьд оны мөн үетэй харьцуулахад хүлээн авсан зөрчил 21664 буюу 59,9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд 56052 иргэнийг шийтгэлийн хуудсаар 2096132,47 төгрөгөөр торгож, 567 хүнийг шүүхээр баривчлуулсан байна. Шүүхээр баривчлуулсан хүний тоо 182 нэгжээр буюу өмнөх оноос 19,3 хувиар өссөн. /урьд онд 475/ Зөрчилд нийт 2739 хүн холбогдон шалгагдсанаас 33 хүүхэд, 382 эмэгтэй хүн байна. Нийгмийн байдлаар авч үзвэл 781 нь буюу 28,5 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 286 буюу 10,4 хувь нь хувийн хэвшлийн байгууллагад ажилдаг 558 буюу 20,3 хувь нь ажилчин малчин иргэд байна.

ТӨВ АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗАР
ШУУРХАЙ УДИРДЛАГЫН ТАСАГ